



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2020.08.31 № 1534
танай _____-ны № _____-т

НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР
ДЭВШИХ ИРГЭН М.НАРАНЖАРГАЛ
ТАНАА

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд бие даан нэр дэвших иргэн Мөнхөөгийн Наранжаргалын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд бие даан нэр дэвших иргэн нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон “Алсын хараа-2050”, Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилтод нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлэн хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд бие даан нэр дэвших иргэний сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, “Алсын хараа 2050”, Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, нийслэлийн 2021-2022 оны төсвийн төсөөлөл, холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

Дүгнэлт

Иргэн Мөнхөөгийн Наранжаргалын нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд бие даан нэр дэвшихээр ирүүлсэн сонгуулийн

мөрийн хөтөлбөр, түүнд тусгагдсан зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, "Алсын хараа-2050", Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Иргэн Мөнхөөгийн Наранжаргалын сонгуулийн мөрийн хөтөлбөр (2 хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Нийслэлийн Сонгуулийн хороонд

Хавсралт: 2 хуудастай

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРДОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б.НОМИНБААТАР



**НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2020 ОНЫ
СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ М.НАРАНЖАРГАЛЫН МӨРИЙН
ХӨТӨЛБӨР**

2020.07.21

Улаанбаатар

ГЭР ХОРООЛЛЫН ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨ ХӨТӨЛБӨР

Өрх бүр орлоготой бол эдийн засгийн өсөлтөд тогтвортой өсөлтийг авч ирэх боломжтой юм. Нийслэл хотод 1,5 сая амьдарч буй бөгөөд 2019 он байдлаар 403 мянган өрх байна. Үүний 50-иас илүү хувь нь хашаанд амьдарч буй. Гэтэл өнөөдөр бид гэр хорооллыг үгүйсгэж, устгах, өөрчлөх тухай ярьсаар. Капитал суурь ойлголт бол газар. Гэтэл Улаанбаатарын дийлэнх айл өрх хашааны 0,07га газартай байгаа нь хамгийн том баялаг бөгөөд хөгжлийн гарц юм. Урбан ферм гэх ойлголт дэлхий нийтээр хөгжиж буй энэ үед хашаандаа органик хүнс тариалан орлогоо нэмэгдүүлэх боломж нь нийслэлийн 50%-д байна.

Гэр хорооллыг хөгжүүлж, ногоон бүс бүхий орчинтой аж ахуйтай орчин үеийн хорооллыг үүсгэхийн төлөө энэхүү мөрийн хөтөлбөрийг таашлуулж байна.

1. Судалгаа, боловсруулалт

- a. Гэр хорооллын айл өрхүүдийн газар, орлого, амьжиргаа, нөхцөл байдлын цогц судалгаа хийх
- b. Гэр хорооллыг хөгжүүлэх хэсэгчилсэн төлөвлөлт хийх
- c. Дэд бүтцийн судалгаа, төлөвлөлт хийх
 - Усны нөөцийн болон усан хангамжийн судалгаа хийх
 - Бие даасан бага оврын хэсэгчилсэн инженерийн төв байгуулах боломжийн судалгаа хийх
 - Хүнсний болон төрөл бүрийн ногоо тариалах боломжийг судлах
 - Зах зээлийн судалгаа хийх
 - ХАА-н бүтээгдэхүүний үнэ цэнийн хэлхээний судалгаа хийх
 - Хүнсний үйлдвэрлэлийг кластераар хөгжүүлэх судалгаа хийх
 - Санхүүжилтын боломж тодорхойлох судалгаа хийх

2. Дэд бүтэц



- a. Гэр хорооллын хэсэгчилсэн төлөвлөлтийн дагуу дүүрэг бүрд бага оврын инженерийн шийдэл бүхий дэд тов байгуулна.
- b. Дэд төвийг хотын төвтэй авто замаар холбоно.
- c. Дэд төвийг цахилгааны төвийн эрчим хүчинд холбох ажлыг хийж гүйцэтгэнэ.

3. Бүтээн байгуулалт

- a. Дэд төвийг түшиглээд ойр орчмын хорооллын хашааны айлуудыг хөгжүүлэх, урбан ферм төсөл хэрэгжүүлнэ.
- b. Дэд төвийг түшиглээд бага оврын тээвэр ложистикийг төв байгуулна.
- c. Дэд төвийг түшиглээд хүнсний агуулах байгуулна.
- d. Нэг дүүрэгт дунджаар 5000 орчим ажлын байрыг бий болгож, нийслэлийн хэмжээнд 10000 айл өрхийг эхний 4 жилд төсөлд хамруулна.

Нэр дэвшигч: 

М.Наранжаргал

